**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт2023**

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилт | хувь |
|---|---|---|---|---|---|
| **нэг.ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 1 | 1 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | 1.“Нээлттэй Дундговь”, Хөрөнгө оруулагчдын чуулганд хамтран ажиллах байгууллагаар сонгогдож арга хэмжээнд оролцож төрийн үйлчилгээний шуурхай байдалд хамтран ажиллах сурталчилгааа, мэдээллийг иргэдэд өгч бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр үзүүлж ажиллалаа.<br>2.Амьдрах орчны эрсдэлийг бууруулах аяны хүрээнд дэд ажлын хэсгийг ахлан хаягжуулалтын асуудлыг аймгийн хэмжээнд цэгцлэхээр холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэл өгч үндэсний телевиз, орон нутгийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилгаа явуулж иргэдийн хүсэлтээр, программын түвшинд хаягийг цэгцлэх ажлыг эхлүүллээ.<br>3. Тус хэлтсээс санаачлан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ‘’Шинэ сэргэлтийн бодлого’’-ын ‘’Хөдөөгийн сэргэлт’’-ийн хүрээнд Дундговь аймагт улсын бүртгэлийн үйлчилгээ, банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг шуурхай авах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалтын хэлтэс,ХХҮГазар, банк санхүүгийн байгууллагууд чөлөөт уулзалтыг зохион байгууллаа. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, чирэгдэл үүсгэхгүй байх, иргэдийг цахим орчинд төрийн үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулахад анхан шатанд шийдвэрлэж болох зарим асуудлыг хамтын ажиллагаан дээр шийдвэрлэх ,холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах саналыг дээд шатны байгууллагууддаа хүргүүлэх саналуудыг нэгтгэн салбар бүрээр гаргалаа. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 19271 иргэн буюу 60.1 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 18 нэгжээр дамжуулан олгохоос гадна Аймгийн Засаг Даргын Тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний Киоск машинаар дамжуулан олгож байна. 2023 онд 7041 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Тоон гарын үсгийг Иргэний үнэмлэхийн чипэнд 16276, 2995 гар утасны апп-д gsign апплекейшнаар дамжуулан олголоо. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 4 жи төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлж ХААН банкнаас улсын хэмжээнд зарласан уралдаанд 3-р байр эзэлж 500.0 төгрөгөөр шагнагдсан. | 100 |

**Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс агентлагт хамааралтай нийтлэг хууль тогтоол шийдвэрийн жагсаалт**

| **№** | **Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн дугаар огноо** | **Заалт** | **Хэрэгжилт** | **Хувь** |
|---|---|---|---|---|
| **Нэг. Монгол улсын хууль** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **1** | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ / 2017-12-07 / | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2021 оны 07 дугаар сар 01-ны өдрийн А-9 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт АЛБАН ХААГЧИЙН "АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ" ХӨТӨЛБӨР 4 зорилт бүхий 9 арга хэмжээг тусган жил бүр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллаж байна. 2023 оны Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. Сургалтын төлөвлөгөөг Хэлтсийн гйүцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар батлан хэрэгжүүлж хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллалаа. 3 зорилтын хүрээнд 11 чиглэлээр сургалт төлөвлөн тухай бүр илтгэх хуудсаар дүгнэж ажилласан бөгөөд 2024 онд 124 сургалтад 984 /албан хаагчдын хувьд давхардсан тоо орсон/ хүнийг хамруулан ажилласан. хэрэгжилтийг 100 хувь хангаг ажиллалаа. | 100 |
| **Хоёр.Засгийн газрын тогтоол** | | | | |
| 2 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүл | 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; | Олон нийтийн цахим сүлжээнд үндэсний бичгээ сурталчлах түгээн дэлгэрүүлэх зорилгоор хэлтсийн цаг үеийн мэдээлэл, гарын авлага, танилцуулгыг Монгол бичиг кирил бичиг хослуулан 9 гарын авлага , 7 хаяг, албан хаагчийн 21 танилцуулга, 21 хувийн хэрэг, анкет, 14 энгэрийн тэмдэг, цахим брошур 9, мэдээллийн самбар болон тараах материал 6ш бэлтгэн ажилласан байна. Нийт 76 ширхэг үндэсний бичиг кирил бичиг хослуулсан материал бэлтгэн ажилласан байна. Мөн хэлтсийн логог монгол бичгээр бичиж гарын авлагад ашиглаж эхэлсэн. | 100% |
| 3 | | 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; | Албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлын хүрээнд А4, А5 болон тушаалын эх загвар бэлтгэн аймгийн архивын тасгаар хянуулан албан бланк 150 ширхгийг хэвлүүлсэн ба кирил явсан бичгийг Монгол бичгээр хөрвүүлэн илгээж туршсан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | жүүл эх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; | Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс Монгол бичгийн цахим хичээлийн сан бүрдүүлж албан хаагчид өдөр бүр цахимаар хичээлээ судлахаас гадна "Хүмүн бичиг" сонинг захиалан уншицгааж байна.<br>Мөн Монгол бичгийн уншлагын чадварыг сайжруулах зорилгоор Бичиг хэргийн ажилтан хариуцан минутын уншлага, эх уншлага арга хэмжээнүүдийг зохион байгуулсан ба албан хаагчдын дундаж уншлагын хурд дунджаар 40 байна. Цаашид тогмолжуулж унших чадварыг сайжруулахаар ажиллаж байна.<br>"Говийн ирээдүй цогцолбор" сургуулийн Монгол хэл уран зохиолын багш М.Нямаа монгол бичгийн 24 цагийн модуль сургалтыг зохион байгуулж дунд шатлалд 15 албан хаагч суралцаж байна. Ахисан шатанд 2 албан хаагч суралцаж монгол бичгээр компьютерт бичих чадварт суралцаж байна. "Хүмүүн бичиг" сонинг жил бүр /улиралд 12 дугаар/ захиалан өөрсдийн мэдлэгийг дээшлүүлэхэд гарын авлага болгон уншицгааж байна.<br>Сонин захиалсан албан хаагчдын тоо 14, Захиалсан сонины тоо улиралд 12 дугаар нийт 48 ширхэг сонин байгууллагын хэмжээнд тухайн онд "Хүмүүн бичиг" сонин 672 ширхгийг худалдан авч уншсан байна. Хүний нөөцийн программ дахь Монгол бичгийн сургалт, Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтын Монгол бичгийн хичээлийг судлан цахимаар болон танхимаар мэдлэгийн хүрээгээ нэмэгдүүлэн ажиллаж байна. Нийт сургалтын тоо 3, зохион байгуулсан сургалтын тоо 2 байна. Сумдын бүртгэгчид сумын ЗДТГ-аас болон цахим сургалтад хамрагдаж байна. | 100% |
| 5 | | 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх | Албан хаагчдын хаалганы хаяг /7 ширхэг хаяг/, мэдээллийн самбар, танилцуулга /21 ширхэг танилцуулга/, хувийн хэрэг /албан хаагчийн 21 хувийн хэрэг/ зэргийг кирилл монгол хосолсон бичгээр албан тушаал, нэрийг бичиж байршуулсан ба албан хэрэгцээнд ашиглаж байгаа хавтас монгол бичгээр нуруу хийсэн. Энгэрийн тэмдгийн монгол бичгийн бичвэрийг файл болгон бэлдэж, эхийг батлуулан хэвлүүлсэн. Албан хэрэгцээнд болон тараах материал, мэдээллийг монгол, кирил бичгээр хослуулан гаргаж байна. | 100% |
| **Хоёр. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах туха | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | 35/45 хэмжээтэй Чингэс хааны эш хөргийг Улсын бүртгэлийн ажилтны өдөр нийт албан хаагчдын баярын хурал дээр хүндэтгэн ажлын байрандаа залж, холбогдох түүхэн барим мэдээллийг Улсын бүртгэгч Б.Одонтунгалаг албан хаагчдад хүргэж ажиллав. | 100% |
| 7 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэр бум мод/ 2021-10-04 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэлтсийн хамт олон тарьсан модны хашаа орчим, модны ухсан нүхний хогийг цэвэрлэж, 5 удаа усалж намрын цэнэг усалгаагаар нийт 60 тарьцны арчилгааг хийлээ. Нөхөн тариалалт 30ш хайлаас суулган ургуулж байна. Ургалтын хувь 90. Усалгаа арчилгааны зардалд 250,0 төгрөг зарцуулаад байна.<br>Хэлтсийн албан хаагчид хувийн хэрэгцээнд 20ш алимны мод худалдан авч суулган 90 хувийн ургалттай байна. Төгсөлт, ТББ-тай хамтран 9 албан хаагч 120 мод тариалсан байна. | 100% |
| **Гурав.ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа | Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 19271 иргэн буюу 60.1 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 18 нэгжээр дамжуулан олгохоос гадна Аймгийн Засаг Даргын Тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний Киоск машинаар дамжуулан олгож байна. 2023 онд 7041 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Тоон гарын үсгийг Иргэний үнэмлэхийн чипэнд 16276, 2995 гар утасны апп-д gsign апплекейшнаар дамжуулан олголоо. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 4 жи төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлж ХААН банкнаас улсын хэмжээнд зарласан уралдаанд 3-р байр эзэлж 500.0 төгрөгөөр шагнагдсан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Хэлтсийн албан хаагчдыг ERP цаг бүртгэлийн системд бүртгэж өглөө орой ирцээ бүртгүүлэх нөхцөлөөр ханган цагийн тооцоо бүртгэлийг систем дээр боловсруулан файлаар хадгалж байгаа нь цаг хугацаа хэмнэж байна.<br>Тайлан, мэдээг дотоод үйл ажиллагааны системээр явуулж, программын хэрэглээг тогтмолжуулсан. Албан хаагчид болон бусад байгууллагатай мэдээ мэдээллийг EDOC системээр солилцож программыг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж байна. Хэлтсийн бүх албан хаагч EDOC системээр албан бичиг солилцож байна. Системийг тогтмол хэрэглэж байгаа 33 албан хаагчтай.<br>Жилийн эцэс буюу 12 дугаар сарын 06-ны байдлаар 507 албан бичиг явуулсан бөгөөд УБЕГ-т 130, хууль хяналтын байгууллагад 215, аймгуудад 80, бусад байгууллагад 82 албан бичиг тус тус явуулсан байна. Тус хэлтсийн хэмжээнд бүртгэгдсэн 601 албан бичиг ирүүлснээс хариутай 243 албан бичиг байгаа бөгөөд бичгийн барагдуулалт 100%, байна. Мөн 40 өргөдөл хүсэлт ирсэн байна.  Ажилтнаас 5, Иргэнээс 35 өргөдөл байна. | | 100 |
| 9 | 6 | 9 | хэрэгжилтийн дундаж хувь | 100 | 100 |

Хэрэгжилт нэгтгэж гаргасан: Улсын бүртгэлийн  Хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал